



## НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2013 оны 02 сарын 01 өдөр

Дугаар A/76

Улаанбаатар хот

Г Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч  
агентлаг Уйлдвэр, хөдөө аж ахуй газрын  
бүтэц, орон тооны тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дугаар хэсэг, Засгийн газрын 2012 оны 190 дүгээр тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Уйлдвэр, хөдөө аж ахуйн газрын дүрмийг нэгдүгээр хавсралтаар, бүтэц, орон тооны хязгаарыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Батлагдсан орон тооны хязгаарт багтаан албан хаагчдыг томилох, цалин нэмэгдлийг зохих журмын дагуу тогоох, байгууллагын дотоод журмыг гарган мөрдөх, үйл ажиллагааны стратеги, хэтийн чиглэлийг боловсруулан 2013 оны эхний хагас жилд багтаан батлуулахыг Уйлдвэр, хөдөө аж ахуйн газар /Г.Пүрэвсүрэн/-т үүрэг болгосугай.
3. Энэ захирамж гарсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2009 оны 172 дугаар, 2010 оны 84 дүгээр захирамжуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР  
ХОТЫН ЗАХИРАГЧ



Э.БАТ-ҮҮЛ

111020000413

Нийслэлийн Засаг даргын 2013 оны  
од зунаар.....сарын .....-ны өдрийн  
А/76 зунаар захирамжийн нэгдүгээр  
хавсралт

УХБ0011 9077243

## НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ АЖ АХҮЙН ГАЗРЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Уйлдвэр, хөдөө аж ахуйн газар /цаашид "газар" гэх/ нь нийслэлийн нутаг дэвсгэрт үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх хэтийн төлвийг тодорхойлох, бодлого, төлөвлөлт, хууль тогтоомж, хөтөлбөр төсөл боловсруулж түүний хэрэгжилтийг хангахад чиглэсэн бодлого, зохицуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын нэгж мөн.

1.2 Газрын үндсэн зорилго нь байгаль орчин, хүн амын эрүүл мэндэд халгүй технологид суурилсан өрсөлдөх чадвар бүхий нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх замаар нийслэлийн хүн амын хүнсний баталгаат байдлыг хангах, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд үзүүлж буй үйлчилгээг шуурхай, чирэгдэлгүй хургэхэд оршино.

1.3 Газар нь үйл ажиллагаандaa Монгол Улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Захиргааны хариуцлагын тухай хууль, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомж, Засгийн газар, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэр, Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, захирамж, тэдгээртэй нийцүүлэн эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэр болон энэхүү дүрмийг удирдлага болгоно.

1.4 Газар нь Нийслэлийн Засаг дарга, Нийслэлийн Засаг даргын Экологи, ногоон хөгжлийн асуудал хариуцсан орлогчийн удирдлага дор өдөр тутмын үйл ажиллагаагаа явуулж, ажлаа тайлагнана.

1.5 Газар нь тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэж, Төрийн сан банкинд харилцах данстай байна.

1.6 Газар нь үйл ажиллагаандaa хууль дээдлэх, ил тод байх, шударга ёсыг хангах зарчмыг баримтлан ажиллана.

Хоёр. Газрын удирдлага, зохион байгуулалт, бүтэц

2.1 Газрын бүтэц, орон тооны дээд хязгаарыг Нийслэлийн Засаг дарга тогтоож, газрын даргыг томилж, чөлөөлнө.

2.2. Газар нь Захиргааны хэлтэс, Үйлдвэрлэлийн хэлтэс, Газар тариалангийн хэлтэс, Эрчимжсэн мал аж ахуйн хэлтэс гэсэн бүтэцтэйгээр үйл ажиллагаагаа явуулах бөгөөд газрын орлогч даргыг Нийслэлийн Засаг дарга болон Нийслэлийн Засаг даргын Экологи, ногоон хөгжлийн асуудал хариуцсан орлогчтой зөвшилцөн газрын дарга томилж, чөлөөлнө.

2.3 Газрын даргыг түр ззгүйд газрын орлогч даргыг орлоно.

2.4 Газар нь ажлаа жил, улирлаар төлөвлөж, тайлан, төлөвлөгөөний биелэлтийг гаргаж ажиллана.

2.5 Газрын дарга нь батлагдсан бүтэц, орон тооны хязгаарт багтаан албан хаагчдыг томилж, чөлөөлөх бөгөөд мэргэжилтнүүдтэй үр дүнгийн гэрээ байгуулж, биелэлтийг дүгнэж, удирдлагад тайлагнана.

2.6 Газрын дарга нь холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актууд, нийслэлийн удирдлагаас өгсөн удирдамж болон энэхүү дүрмийн дагуу үйл ажиллагаагаа явуулах ба ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг баталгаажуулж, өдөр тутмын ажлыг удирдан, цаг үеийн ажлыг зохион байгуулж, дор дурдсан ажлуудыг тогтмол хэрэгжүүлнэ. Үнд:

а/ Ажилтан бүрийг жил, улирлын үйл ажиллагааны төлөвлөгөөтэй ажиллуулан, улирал бүр ажлын тайлан гаргуулж, мэргэшлийн үр чадвар, үр дүнгийн гэрээний тайланг хагас, бүтэн жилээр үнэлэн зохих журмын дагуу шагнаж урамшуулах;

б/ Газрын жил, улирлын төлөвлөгөө, үр дүнгийн гэрээний хэрэгжилт, тайлангийн боловсруулалтад хяналт тавих;

в/ Газрын дотоод ажлыг зохион байгуулж, удирдах дээд байгууллагууд болон Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг даргын шийдвэрүүд, удирдлагуудаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангун, газрын ажилтнуудад хугацаатай үүрэг, даалгавар өгч, биелэлтийг хангах;

г/ Нийслэлийн нутаг дэвсгэр дэх аж ахуйн нэгж, төрийн бус болон судалгааны байгууллагууд, олон улсын төсөл хэрэгжүүлэгч байгууллагуудтай холбогдох журмын харилцах;

д/ Газрын ажилтныг шагнаж урамшуулах, сахилгын арга хэмжээ авах, нийгмийн асуудлыг нь шийдвэрлэх, гадаад, дотоодын мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах зэрэг асуудлыг шийдвэрлэх.

Гурав. Үйл ажиллагааны үндсэн чиглэл, эрх, үүрэг

### 3.1. Үндсэн чиглэл

Газар нь Улаанбаатар хотын үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх бодлого, чиг хандлагатай нийцүүлэн хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэх үе шатны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний санал боловсруулах,

тодотгох, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтаар нийслэлд хэрэгжих үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх, хөтөлбөр, төслийн баримт бичгийг уялдуулан зохицуулах, гүйцэтгэлийг нийслэлийн удирдлагын өмнө хариуцна.

3.1.1 Нийслэлийн эдийн засагт боловсруулах аж үйлдвэрийн салбарын эзлэх хувийн жинг өсгөх, үйлдвэрийн оновчтой бүтэц бий болгох, байгаль орчин, хүн амын эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг арилгах хүрээнд үйлдвэрлэл технологийн парк байгуулах ажлыг хэрэгжүүлнэ.

3.1.2 Монгол Улсын Засгийн газрын өндөр технологийг дэмжих үйл ажиллагааг нийслэлийн түвшинд хэрэгжүүлж, аутсорсингийн үйлчилгээг нэвтрүүлэх зохицуулалтын арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.1.3 Нийслэлийн хэмжээнд ажилгүйдлийг бууруулах зорилгоор жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих үйл ажиллагааг зохион байгуулна.

3.1.4 Төрийн бодлогын хүрээнд нийслэлийн үйлдвэржүүлэлтийн бодлогыг хэрэгжүүлэх оновчтой арга хэлбэрүүдийг боловсруулан төлөвшүүлэхэд чиглэгдсэн ажлыг зохион байгуулах, биелэлтийг хангуулахад хяналт тавьж ажиллана.

3.1.5 Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг эрчимжүүлэн хөгжүүлэх, хөдөө аж ахуйн талаархи хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтийг хангуулж, орон нутгийг мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангах, үйлчилгээ үзүүлэх, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн цаг үеийн ажлыг нэгтгэн зохион байгуулж, шаардлагатай асуудлаар шуурхай зохицуулалт хийх талаар арга хэмжээг төлөвлөж батлуулан хэрэгжүүлэх, үр дүнг тайлагнах ажил, үйлчилгээг эрхэлнэ.

3.1.6 Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх ажлыг зохион байгуулж, мал аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт, дэвшилтээ технологийг нэвтрүүлэн, малын үүлдээрлэг байдлыг сайжруулж, нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх замаар өндөр ашиг шим бүхий зохистой тооны мал сүргийг мал аж ахуй эрхлэхийг зөвшөөрсөн бусэд үржүүлэхэд /фермерийн аж ахуйг хөгжүүлэхэд/ дэмжлэг үзүүлэх.

3.1.7 Газар тариалангийн үйлдвэрлэлд эрчимжсэн технологийн шинэчлэл хийх, үр, сортын бодлого боловсруулж хэрэгжүүлэх, таримал ургамлыг хамгаалах, хамгаалагдсан хөрсний аж ахуйг хөгжүүлэх, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд иргэдийн оролцоог идэвхжүүлэх, зохион байгуулах, зохицуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

3.1.8 Салбарын үйлдвэрлэлийн бүтээмж, үр ашгийг дээшлүүлэх, аж ахуйн нэгж, иргэдийг хөрөнгө оруулалт, зээлийн бодлогоор дэмжиж, хууль, эрх зүйн орчинг шинэчлэх асуудлаар санал боловсруулж, холбогдох байгууллагуудаар шийдвэрлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх.

3.1.9 Үйлдвэржүүлэлт, хөдөө аж ахуйн бодлогын асуудлаар хөтөлбөр, тесөл, чухал ач холбогдолтой бусад асуудал боловсруулан Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулж, хэрэгжилтийг хангах.

3.1.10 Монгол улсын Засгийн Газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн болон Нийслэлийн эдийн засаг, нийгмийн зорилтын хэрэгжилт, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан асуудлын биелэлт, Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор батлагдсан үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн салбарын үндэсний хөтөлбөрүүд, НИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын тогтоолоор батлагдсан дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангаж, биелэлтийг гарган холбогдох байгууллагуудад хүргүүлэх ажлыг зохион байгуулах

### 3.2. Газрын үүрэг

3.2.1 Монгол Улсын Засгийн газрын болон нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн тухайн жилийн зорилтод нийслэлийн үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх бодлогыг тусгуулан батлуулж, түүнийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн ажлыг зохион байгуулах.

3.2.2 Нийслэлийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан үйлдвэржүүлэлт, эрчимжсэн мал аж ахуй, газар тариалантай холбоотой төсөл хөтөлбөр, түүний зураг төсөл, техникийн даалгаврыг хянаж санал оруулах.

3.2.3 Нийслэл Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан үйлдвэржүүлэлт, хөдөө аж ахуйн бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулна.

3.2.4 Нийслэлийн үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн салбарын мэдээллийн санг бүрдүүлж, түүний баяжилтыг тогтмолжуулна.

3.2.5 Иргэдийн оролцоо, санал хүсэлтэд тулгуурлан үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн салбарт ашиглах дотооддоо үйлдвэрлэх боломжгүй техник, сэлбэг, тоног төхөөрөмж, эрдэс бордоо, ургамал хамгааллын бодис, таримал ургамлын шинэ сортын үр, суулгац, өндөр ашиг шимт үржлийн мал, амьтан, тэдгээрийн үр хөврөл, үрийг импортын татвар болон нэмэгдсэн өргтийн татвараас хөнгөлөх, чөлөөлөх асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх.

3.2.6 Үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн салбарт олгосон гадаадын зээл тусламжийн хөрөнгийг нийслэлийн хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх зорилгод ашиглах асуудлыг холбогдох дээд байгууллагад тавьж шийдвэрлүүлэн зохицуулах.

3.2.7 Улаанбаатар хотын хөгжил, эрэлт хэрэгцээнд нийцсэн ажлын байрыг бий болгох арга хэмжээг төрийн захирагааны төв байгууллага, төрийн бус байгууллага, хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлэх.

3.2.8 Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаагаа явуулдаг үйлдвэрийн газруудад Монгол Улсын хууль тогтоомж, норм норматив, дүрэм, журмын дагуу үйл ажиллагаагаа явуулахад нь арга зүйн зөвлөгөө өгөх, хэрэгжилтийг хангулж, гарсан зөрчлийг арилгах асуудлыг холбогдох байгууллагуудад нь уламжилан, хууль тогтоомжийн дагуу шуурхай шийдвэрлүүлэх.

3.2.9 Хотын хөгжлийн хэтийн төлөв, бодлогод тусгагдсан үйлдвэржүүлэлтийн бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийслэл, дүүргийн аж ахуйн нэгж, байгууллагуудтай хамтран ажиллах.

3.2.10 Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн үйлдвэржүүлэлтийн бодлогын хэрэгжилтийн биелэлтийг нэгтгэн гаргахад шаардагдах судалгаа, тооцоо, мэдээллийг Захирагчийн ажлын албаны хэлтэс, дүүргийн Засаг даргын Тамгын газар, харьяа байгууллага, нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгжүүдээс гаргуулан авч, шаардлагатай тохиолдолд мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулах.

3.2.11 Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд бизнес инкубацийн үйлчилгээг үзүүлэх, тэдгээрийг бойжуулах, хөнгөлөлттэй зээлд хамруулах ажлыг нийслэлийн холбогдох нэгжүүдээр дамжуулан гүйцэтгүүлэх.

3.2.12 Малын үүлдэр угсааг сайжруулж ашиг шимийг нэмэгдүүлэхэд биотехнологийн дэвшилтэй аргыг нэвтрүүлэх ажлыг төрийн захиргааны төв болон салбарын шинжлэх ухааны байгууллагуудтай хамтран зохион байгуулах.

3.2.13 Мал, тэжээвэр амьтны тэжээлийн үйлдвэрлэл эрхлэхийг бүх талаар дэмжиж ажиллах.

3.2.14 Мал сүргийг индексжүүлж, им, тамгажуулах ажлыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах

3.2.15 Усалгаатай газар тариаланг өргөжүүлэх ажиллагааг эрчимжүүлэх, хамгаалагдсан хөрсний /хучлагатай талбай, хүлэмж/ болон төмс, хүнсний ногооны тариалалтыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

3.2.16 Өрх бүрийг хүнсний ногоо, жимс, жимсгэнэ тариалах хөдөлгөөнд хамруулж, өрхийн тариаланг дэмжих зорилгоор төмс, хүнсний ногооны үр, үрслэг, жимсний суулгац, тарьцыг хөнгөлөлттэй үнэ болон зээлээр нийлүүлэх, суулгац үйлдвэрлэх санаачлагыг дэмжин туслах.

3.2.17 Байгаль орчин, бүтээгдэхүүний чанарт серөг нөлөөгүй аргаар тариалангийн хог ургамал, өвчин, хортон шавьж, мэрэгчидтэй тэмцэх арга ажиллагааг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах.

3.2.18 Ажилтнуудаар териийн албаны ёс зүйн хэм хэмжээг баримтлуулж, иргэд, байгууллагын санал хүсэлтийг хуулинд заасан хугацаанд шийдвэрлэн, мэдээг зохих хугацаанд гаргаж ажиллах.

3.2.19 Холбогдох хууль тогтоомж, газрын дотоод журмын дагуу ажиллагсадын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, мэдлэг боловсрол, мэргэжлийн үр чадварыг дээшлүүлэх, туршлага судлуулах зэрэг сургалтын зохистой арга хэлбэр, хамрах хүрээг өргөжүүлэх талаар шат дараалсан арга хэмжээг авах.

### 3.3. Газрын эрх

3.3.1 Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаагаа явуулдаг үйлдвэрийн газруудад Монгол Улсын хууль, норм норматив, дүрэм, журмын дагуу үйл ажиллагаагаа явуулахад нь арга зүйн зөвлөгөө өгөх, хэрэгжилтийг хангулж, гарсан зөрчлийг арилгах асуудлыг холбогдох байгууллагуудад нь уламжлах, шуурхай шийдвэрлүүлэх

3.3.2 "Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий тодотголын тухай", "Хотыг дахин хөгжүүлэх тухай", "Нийслэлийн эрх зүйн байдлын тухай" болон холбогдох бусад хууль тогтоомж, хөтөлбөр, Төр захиргааны төв байгууллагуудтай хамтран ажиллах бичиг баримтууд, дүрэм, журам, норм нормативыг боловсронгуй болгоход холбогдох байгууллагуудад санал өгөх, өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дагалдах дүрэм журмыг боловсруулах

3.3.3 Хотын хөгжлийн хэтийн төлөв, бодлогод тусгагдсан үйлдвэржилт, хөдөө аж ахуйн бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийслэл, дүүргийн аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран ажиллах

3.3.4 Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн үйлдвэржилт, хөдөө аж ахуйн бодлогын хэрэгжилтийг гаргахад шаардагдах судалгаа, тооцоо, мэдээллийг дүүргийн Засаг даргын тамгын газар, харьяа байгууллага, нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгжүүдээс гаргуулан авч, шаардлагатай тохиолдолд тухайн салбарын мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулах

3.3.5 Жижиг, дунд болон өрхийн үйлдвэрлэл эрхлэгчид, хоршоологчдод сургалт явуулж, зөвлөлгөө өгөх, дэмжиж туслах инкубатор төв, дадлагын бааз /агропарк/, сургалтын төв /экстейшн/ байгуулах, тэдгээрийг мэргэжил арга зүй, удирдлагаар хангах.

3.3.6 Үйлдвэр, хөдөө аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, иргэдэд шаардлагатай үед мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр сурталчлах, газрын хариуцах асуудлаар онол, арга зүйн хурал, семинар зөвлөлгөөн, сургалт зохион байгуулах

3.3.7 Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хэлтсүүд, Захирагчийн ажлын алба, хэрэгжүүлэгч агентлаг, харьяа газар, бусад байгууллагатай хамтран ажиллах

### Дөрөв. Хариуцлага

4.1 Газрын дарга, ажилтнууд нь үр дүнгийн гэрээ болон энэхүү дүрмээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн, Төрийн албан хаагчийн ёс зүйн алдаа гаргасан, дагаж мөрдөх хууль тогтоомжийг зөрчсөн тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнз.

## Тав. Бусад

5.1 Газрын эрх хэмжээнд багтас асуудлаар шуурхай зөвлөлгөөнийг 14 хоног тутамд хийж, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдах ажилтны шуурхай зөвлөлгөөний дүн, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх болон ажилтнуудаас хариуцан гүйцэтгэх цаг үеийн ажил, албан хаагчдын ёс зүй, хариуцлага, санаачилга, өгсөн үүрэг даалгаврын биелэлт, ажлын арга барил, үр дүнг сайжруулах асуудлыг хэлэлцэн тэмдэглэл хөтөлнө.

5.2 Газар нь ажилтнуудынхаа мэдлэг, мэргэшил, үр чадварыг дээшлүүлэх асуудлыг ажлын байрнаас нь хөндийрүүлэлгүй зохион байгуулах, ахмад, ажлын дадлага туршлагатай болон залуу шинэ ажилтнуудыг хослуулан ажиллуулах, харилцан туслалцуулах ажлыг үр дүнтэй хэрэгжүүлнэ.

5.3 Хэлтэс нь ажилтнуудынхаа эрүүл мэндийг хамгаалах, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, ажлын байрны тав тух, соёлыг дээшлүүлэх, ар гэр, ахуй амьдралд нь туслалцаа үзүүлэх, хамт олныг төлөвшүүлэхэд чиглэгдсэн ажлыг санаачлан зохион байгуулан ажиллана.

5.4 Энэхүү дүрэмд Нийслэлийн Засаг даргын захирамжаар нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд тэдгээр нь дурмийн салшгүй хэсэг болно.

5.5 Энэхүү дүрэмд орсон нэмэлт өөрчлөлтийг тухай бүр зохих эрх бүхий байгууллагад мэдэгдэж бүртгүүлнэ

-----oOo-----

Нийслэлийн Засаг даргын 2013 оны  
02 сарын 01-ны өдрийн  
А) № 26 зурагт захирамжийн хөөрдүгаар  
хавсралт

УЧБН/ЗСН/БД/77343

НИЙСЛЭЛИЙН ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН  
БҮТЭЦ, ОРОН ТООНЫ ХЯЗГААР

д/д	Хэлтэс, алба	Орон тоо
1	<ul style="list-style-type: none"><li>- Захиргааны хэлтэс</li><li>- Үйлдвэрлэлийн хэлтэс</li><li>- Эрчимжсэн мал аж ахуйн хэлтэс</li><li>- Газар тариалангийн хэлтэс</li></ul>	<p>Нийт орон тоо 36 Үүнээс</p> <ul style="list-style-type: none"><li>- Дарга</li><li>- Орлогч дарга /2/</li><li>- Төрийн захиргааны албан хаагч /33/</li></ul>